

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД, САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2012 оны 02 дугаар сарын 01 өдөр

Дугаар А/20/21

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 6 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.“Даатгалын тохиолдлын тодорхойлолтыг бүрдүүлэх заавар”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Даатгалын тохиолдлын тодорхойлолтын маягтыг бөглөх аргачлал”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэ тушаалыг 2012 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3.Энэ журмын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газар /С.Ганболд/, Цагдаагийн ерөнхий газар /Д.Сандаг-Очир/-т тус тус даалгасугай.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙД

Ц.НЯМДОРЖ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ДААТГАЛЫН ТОХИОЛДЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫГ БҮРДҮҮЛЭХ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ зааврын зорилго нь жолоочийн даатгалын тохиолдол үүссэн үед зам тээврийн ослын нөхцөл байдлыг үнэн зөв тодорхойлох боломжийг бүрдүүлэхэд оршино.

Хоёр. Даатгалын тохиолдлын тодорхойлолтын маягт бөглөх, ашиглах

2.1. Даатгалын тохиолдлын тодорхойлолтын маягт /цаашид “тодорхойлолтын маягт” гэх/-ыг зам, тээврийн осол, зөрчилд өртсөн, ослын улмаас бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учраагүй, осолд өртсөн жолооч нар харилцан тохиролцож, зөвшөөрсөн тээврийн хэрэгслийн жолооч байна.

2.2. Зам тээврийн ослын улмаас эд хөрөнгөд хохирол учирсан бол жолооч нь харилцан зөвшөөрч гарын үсэг зурсан даатгалын тохиолдлын маягтыг үндэслэн зохих журмын дагуу нөхөн төлбөр гаргуулж болно.

2.3. Энэ зааврын 2.4-т заасан хохирогчид олгох нөхөн төлбөр олгохтой холбогдон үүссэн маргааныг Даатгалын тухай хуулийн 82 дугаар зүйлд заасан журмаар шийдвэрлүүлнэ.

2.4. Даатгалын тохиолдлын улмаас *тээврийн* хэрэгслийн жолооч нас барсан, эрүүл мэндэд нь хохирол учирснаас өөрийн үйлдлийг удирдан жолоодох чадваргүй болсон бол шуурхай алба, цагдаагийн байгууллагад мэдэгдэж, холбогдох хууль тогтоомжийн дагуу шалгаж, шийдвэрлүүлнэ.

Гурав. Жолоочийн үүрэг

3.1. Зам тээврийн осолд өртсөн жолооч нь дараах үүрэгтэй:

3.1.1. тодорхойлолтын маягтыг бөглөх;

3.1.2. осолд оролцсон талууд гарын үсэг зурсанаас хойш тодорхойлолтын маягтад засвар, өөрчлөлт оруулахгүй байх;

3.1.3. хохирогчтой тохиролцсоны үндсэн дээр даатгагчид мэдэгдэн эргэн төлүүлэх нөхцөлтэйгээр түүний өгсөн зааврын дагуу хохирлыг шуурхай барагдуулах;

3.1.4. хууль тогтоомжид заасан үүргээ хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүйн улмаас үүсэх үр дагаврыг өөрөө хариуцах;

Дөрөв. Даатгагч, жолоочийн даатгалын сангийн үүрэг

4.1. Даатгагч, жолоочийн даатгалын сан нь дараах үүрэгтэй:

4.1.1. тодорхойлолтын маягт болон холбогдох бусад баримт бичгийг үндэслэн хохирогчид нөхөн төлбөр олгох;

4.1.2. даатгалын тохиолдлын талаарх мэдээллийг нэн даруй цагдаагийн байгууллагад дамжуулах, тодорхойлолтын маягтын эх хувийг хүлээлгэн өгөх;

4.1.3. даатгалын тохиолдлын талаарх мэдээллийг хүлээн авсан даруйд даатгагч, шуурхай алба нь төлөөлөгчөө шуурхай илгээх;

4.1.4. даатгалын тохиолдлын улмаас хүний амь нас, эрүүл мэнд хохирсон бол цагдаагийн байгууллагад мэдэгдэж, холбогдох хууль тогтоомжийн дагуу шалгуулах;

4.1.5. даатгагч, даатгалын сангийн төлөөлөгч нь зам тээврийн осолд үзлэг хийж буй цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохгүй байх;

Тав. Хохирогчийн эрх, үүрэг

5.1.Зам тээврийн осолд өртсөн хохирогч дараах эрх, үүрэгтэй:

5.1.1.зам тээврийн осол гаргасан жолоочтой харилцан тохиролцож, хохирлоо газар дээр нь барагдуулах;

5.1.2.даатгалын тохиолдол гаргасан жолооч зугтаасан талаар шуурхай алба, цагдаагийн байгууллагад мэдэгдэх;

5.1.3.амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд нь учирсан хохирлыг нотлох бүх мэдээллийг даатгагч, жолоочийн даатгалын сангийн төлөөлөгч, цагдаагийн алба хаагчид гаргаж өгөх.

Зургаа. Хяналт, хариуцлага

6.1. Энэ зааврын биелэлтэд Санхүүгийн зохицуулах хороо хяналт тавьж ажиллах бөгөөд буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

-----oOo-----

Даатгалын тохиолдлын тодорхойлолтын маягт

Энэхүү маягыг тээврийн хэрэгслийн жолооч бөглөнө. Зам тээврийн ослын нөхцөл байдал, түүнд оролцогчдын талаарх мэдээллийг агуулна.

1. Зам тээврийн осол болсон газар:

(хот (аймаг), дүүрэг (сум), хороо (баг) замын орчны байрлал)

2. Огноо 3. Осолдөртсөн тээврийн хэрэгслийн тоо

өдөр, сар, он цаг, минут тоо тоо

4. Бусад тээврийн хэрэгсэлд учирсан хохирол байгаа эсэх ("А" ба "В"-ээс бусад) Тийм Үгүй Бусад хөрөнгөд Тийм Үгүй

зөвийг тэмдэглэх

5. Зам тээврийн ослын талаардаатгалд мэдээлэл өгсөн хүний нэр:---

6. Зам тээврийн ослын гэрч:

(овог, нэр, оршин суух хаяг, холбоо барих утасны дугаар)

7. "А" тээврийн хэрэгслийн мэдээлэл /ТХ/

ТХ-ийн марк, загвар _____

ТХ-ийн арлын дугаар (VIN)

ТХ-ийн улсын дугаар

ТХ-ийн гэрчилгээ

сери дугаар

Жолооны хүрдний байрлал: зүүн баруун

ТХ үйлдвэрлэсэн огноо: -----

ТХ-ийн төрөл:

<input type="checkbox"/> Суудлын	<input type="checkbox"/> ачааны
<input type="checkbox"/> Автобус	<input type="checkbox"/> мотоцикл
<input type="checkbox"/> механизм	<input type="checkbox"/> толлейбус

ТХ-ийн гүйлт /км/: -----

8. Жолоодож явсан хүний мэдээлэл

ТХ-ийн өмчлөгч _____

(овог,

_____ нэр (хуулийн этгээд бол нэрийг бүрэн бичнэ))

Хаяг _____

ТХ-ийн жолооч _____

(овог, нэр)

Регистрийн дугаар:

өдөр, сар, он

Хүйс: Эрэгтэй эмэгтэй

Хаяг _____

Утас:

Жолооны үнэмлэх

сери дугаар

Ангилал

А B C D E олгосон огноо

Тээврийн хэрэгслийг ТХ-ийн өмчлөгч

жолоодож явсан ТХ-ийг жолоодох зөвшөөрөгдсөн

этгээд жолооч

9. Даатгагч

(жолоочийн хариуцлагыг даатгасан даатгагч)

Даатгалын баталгаа

сери дугаар

Хүчинтэй хугацаа

өдөр, сар, он

ТХ даатгалтай эсэх Үгүй Тийм

* "А" ТХ-ийн жолооч өөрийн ТХ-ийн талаар бөглөнө.

"А" ТХ-ийн жолоочийн гарын үсэг _____

"А" 10. Зам тээврийн осол гарсан "В" шалтгаан (зөвийг чагтлах)

<input type="checkbox"/> 1	Согтуугаар т/х жолоодсон	<input type="checkbox"/> 1
<input type="checkbox"/> 2	Уулзвар гарц нэвтрэх журам	<input type="checkbox"/> 2
<input type="checkbox"/> 3	Эсрэг урсгалд орсон	<input type="checkbox"/> 3
<input type="checkbox"/> 4	Ухрах үйлдэл буруу хийсэн	<input type="checkbox"/> 4
<input type="checkbox"/> 5	Хурд хэтрүүлсэн	<input type="checkbox"/> 5
<input type="checkbox"/> 6	Гэрэл дохио зөрчсөн	<input type="checkbox"/> 6
<input type="checkbox"/> 7	Эгнээ байр буруу эзэлсэн	<input type="checkbox"/> 7
<input type="checkbox"/> 8	гадны гэрэл буруу хэрэглэсэн	<input type="checkbox"/> 8
<input type="checkbox"/> 9	Бүрэн бус т/х жолоодсон	<input type="checkbox"/> 9
<input type="checkbox"/> 10	Эргэх үйлдэл буруу хийсэн	<input type="checkbox"/> 10
<input type="checkbox"/> 11	Хүн ба ачаа тээвэрлэх журам	<input type="checkbox"/> 11
<input type="checkbox"/> 12	Анхаарал болгоомжгүй	<input type="checkbox"/> 12
<input type="checkbox"/> 13	Хоорондын зай тохируулаагүй	<input type="checkbox"/> 13
<input type="checkbox"/> 14	Замын нөхцлөөс	<input type="checkbox"/> 14
<input type="checkbox"/> 15	Зогсоох арга хэмжээ аваагүй	<input type="checkbox"/> 15
<input type="checkbox"/> 16	Гүйцэж түрүүлэх үйлдэл буруу	<input type="checkbox"/> 16
<input type="checkbox"/> 17	Бусад	<input type="checkbox"/> 17

11. Зам тээврийн осол гарсан хэлбэр

<input type="checkbox"/> 1	т/х т/х-тэй урд талаараа мөргөлдсөн	<input type="checkbox"/> 1
<input type="checkbox"/> 2	т/х т/х-тэй ард талаараа мөргөлдсөн	<input type="checkbox"/> 2
<input type="checkbox"/> 3	т/х т/х-тэй хажуу талаараа мөргөлдсөн	<input type="checkbox"/> 3
<input type="checkbox"/> 4	т/х-ээр байшин, барилга байгууламж мөргөсөн	<input type="checkbox"/> 4
<input type="checkbox"/> 5	т/х-ээр замын тэмдэг мөргөсөн	<input type="checkbox"/> 5
<input type="checkbox"/> 6	т/х-ээр тусгаарлах зурвас мөргөсөн	<input type="checkbox"/> 6
<input type="checkbox"/> 7	т/х-ээр гүүр, далан мөргөсөн	<input type="checkbox"/> 7
<input type="checkbox"/> 8	т/х-ээр гэрлийн шон, хашлага мөргөсөн	<input type="checkbox"/> 8
<input type="checkbox"/> 9	Онхолдсон	<input type="checkbox"/> 9
<input type="checkbox"/> 10	Явган зорчигч т/х-ийн урдуур	<input type="checkbox"/> 10

<input type="checkbox"/>	явж байхад мөргөсөн	<input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 11	Явган зорчигч т/х-ийн зэрэгцээ явж байхад мөргөсөн	<input type="checkbox"/> 11
<input type="checkbox"/> 12	Явган зорчигч зам дээр зогсож, ажиллаж байхад мөргөсөн	<input type="checkbox"/> 12
<input type="checkbox"/> 13	Бусад	<input type="checkbox"/> 13

7. "В" тээврийн хэрэгслийн мэдээлэл /ТХ/

ТХ-ийн марк, загвар _____

ТХ-ийн арлын дугаар (VIN)

ТХ-ийн улсын дугаар

ТХ-ийн гэрчилгээ

сери дугаар

Жолооны хүрдний байрлал: зүүн баруун

ТХ үйлдвэрлэсэн огноо: -----

ТХ-ийн төрөл:

<input type="checkbox"/> суудлын	<input type="checkbox"/> ачааны
<input type="checkbox"/> автобус	<input type="checkbox"/> мотоцикл
<input type="checkbox"/> механизм	<input type="checkbox"/> бусад

ТХ-ийн гүйлт /км/: -----

8. Жолоодож явсан хүний мэдээлэл

ТХ-ийн өмчлөгч _____

(овог,

_____ нэр (хуулийн этгээд бол нэрийг бүрэн бичнэ))

Хаяг _____

ТХ-ийн жолооч _____

(овог, нэр)

Регистрийн дугаар:

өдөр, сар, он

Хүйс: Эрэгтэй эмэгтэй

Хаяг _____

Утас:

Жолооны үнэмлэх

сери дугаар

Ангилал

А B C D E олгосон огноо

Тээврийн хэрэгслийг ТХ-ийн өмчлөгч

жолоодож явсан ТХ-ийг жолоодох зөвшөөрөгдсөн

этгээд жолооч

9. Даатгагч

(жолоочийн хариуцлагыг даатгасан даатгагч)

Даатгалын баталгаа

Хүчинтэй хугацаа

ТХдаатгалтай эсэх Үгүй Тийм

* "B" ТХ-ийн жолооч өөрийн ТХ-ийн талаар бөглөнө.

"B" ТХ-ийн жолоочийн гарын үсэг

12. Зам тээврийн осол гарсан замын нөхцөл байдал

"А"		"В"
Замын хучилт:		
<input type="checkbox"/> 1	Асф-бет	1 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 2	Цем-бет	2 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 3	сайжруулсан	3 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 4	хөрсөн	4 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 5	хайрган	5 <input type="checkbox"/>
Замын гадаргуугийн байдал:		
<input type="checkbox"/> 1	хуурай	1 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 2	нойтон	2 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 3	цастай	3 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 4	мөстэй	4 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 5	эвдрэлтэй	5 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 6	бохирдсон	6 <input type="checkbox"/>
Замын хэсэг:		
<input type="checkbox"/> 1	уулзвар	1 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 2	гарц	2 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 3	Явган хүний гарц	3 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 4	Автобусны буудал	4 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 5	Төмөр замын гарам	5 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 6	гүүр	6 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 7	хонгил	7 <input type="checkbox"/>



Гэмтлийн нүдээр харагдах байдал

"А" ТХ-ийн жолоочийн гарын үсэг

"А"		"В"
Үзэгдэх орчин:		
<input type="checkbox"/> 1	Чөлөөтэй	1 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 2	Хязгаарлагдмал	2 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 3	Хангалтгүй	3 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 4	Зорчих хэсэг гэрэлтүүлэгтэй	4 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 5	Зорчих хэсэг гэрэлтүүлэггүй	5 <input type="checkbox"/>
Замын онцлог:		
<input type="checkbox"/> 1	Тэгш	1 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 2	Хазгай	2 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 3	Шулуун	3 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 4	Өгсүүр	4 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 5	Уруу	5 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 6	Огцом эргэлт	6 <input type="checkbox"/>

15. Зам тээврийн ослын зураглал

15.Зам тээврийн ослын зураглал

.....

Хоёр жолооч бүртгэ бөглөснөөс хойш аливаа өөрчлөлт хийхийг хориглоно.

"А"		"В"
Замын ангилал:		
<input type="checkbox"/> 1	Ердийн зам	1 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 2	Хорооллын зам	2 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 3	Тууш зам	3 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 4	Хорооллын зам	4 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 5	Аж ахуйн нэгж байгууллагын доторхи зам	5 <input type="checkbox"/>
Бусад:		
<input type="checkbox"/> 1	Суурингийн замд	1 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 2	Суурингийн гаднах замд	2 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 3	өдөр	3 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 4	шөнө	4 <input type="checkbox"/>

13. Учирсан хохирол

"А" жолоочид Учирсан эд материалын мөнгөн дүн:

Нөхөн төлүүлсэн мөнгөн дүн:

"В" жолоочид Учирсан эд материалын мөнгөн дүн:


Нөхөн төлүүлсэн мөнгөн дүн:

1. Замын дүрслэл – гудамжны нэрийг оруулна.
2. "А" ба "В" ТХ-ийн хөдөлгөөний чиглэл.
3. "А" ба "В" ТХ-ийн мөргөлдөх үеийн байрлал.
4. "А" ба "В" ТХ-ийн эцсийн байдал.
5. Замын тэмдэг, тэмдэглэгээ, гэрэл дохио.

14. Анхны цохилт өгсөн газар
Сумаар заах (→)

15.Зам тээврийн ослын товч утга:

14. Анхны цохилт өгсөн газар
Сумаар заах (→)



Гэмтлийн нүдээр харагдах байдал

“B” ТХ-ийн жолоочийн гарын үсэг

16. Зам тээврийн осолд 2-оос дээш тооны ТХ оролцсон бол тэдгээр ТХ-ийн талаарх мэдээлэл

_____ (ТХ-ийн марк, загвар, улсын дугаар;

_____ даатгагч, даатгалын баталгааны сери, дугаар)

17. ТХ-д учирснаас бусад хөрөнгөд учирсан хохирол

Нэр төрөл _____ (гэмтсэн зүйлийн нэр төрөл)
Хэний хөрөнгө болох _____ (баримтаар нотлогдвол бөглөнө)

18. ТХ-ийг хөдөлгөж явуулах боломжтой эсэх?

Тийм Үгүй
"Үгүй" бол ТХхаана байгаа талаар _____

19. Тэмдэглэл:

" _____ " _____ 20 ____ . _____ (бөглөсөн огноо) _____ (гарын үсэг) _____ (Овог, нэр (гарын үсгийн тайлал)) _____)

15 хоногийн дотор даатгагчид өгнө.

Зам тээврийн осолд холбогдсон талууд маргаантай тохиолдолд цагдаагийн байгууллагад хандаж асуудлаа шийдвэрлүүлнэ.

*Хууль зүй, дотоод хэргийн сайд,
Санхүүгийн зохицуулах хорооны даргын
хамтарсан 2012 оны 02 дугаар сарын 01-
ний өдрийн А/20/21 дүгээр тушаалын
хоёрдугаар хэсэрт*

ДААТГАЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН МАЯГТЫГ БӨГЛӨХ АРГАЧЛАЛ

1. Даатгалын тодорхойлолтын маягтыг дараах утгаар ойлгож, бөглөнө:

1.1. Зам тээврийн осол болсон газар гэдэгт тухайн зам тээврийн осол болсон аймаг, сум, дүүргийн нэр, хорооны дугаар, осол болсон замын байршил зэргийг тодорхой бичнэ. Тухайлбал: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 15 дугаар хороо, Их дэлгүүрийн баруун уулзвар гэх мэт.

1.2. Огноо гэдэгт тухайн автотээврийн осол гарсан он, сар, өдөр, цаг, минутыг бичнэ.

1.3. Осолд өртсөн тээврийн хэрэгслийн тоог нүдэнд бичнэ.

1.4. Бусад тээврийн хэрэгсэлд учирсан хохирол байгаа эсэх гэдэгт- “А” ба “В” талуудаас бусад тээврийн хэрэгсэлд болон хөрөнгөнд учирсан хохирол байгааг- тийм, үгүй гэсэн нүдэнд аль зөвийг чагталж бичнэ.

1.5. Тухайн тээврийн хэрэгслийн ослын талаар даатгалд мэдээлэл өгсөн хүний овог, нэрийг бичнэ.

1.6. Зам тээврийн ослын гэрч гэдэгт- тухайн зам тээврийн ослын гэрчээр орж байгаа этгээдийн овог, нэр оршин суух хаяг, холбоо барих утасны дугаар зэргийг тодорхой бичнэ.

1.7. Тээврийн хэрэгслийн мэдээлэл гэдэгт- тухайн зам тээврийн осол гаргасан тээврийн хэрэгслийн марк, загвар, тээврийн хэрэгслийн улсын дугаар, сери, арлын дугаарыг заасан нүдэнд багтаан бичнэ. Жолооны хүрдний байрлалыг баруун, зүүн гэх нүдэнд чагталж бичнэ. Тээврийн хэрэгслийн үйлдвэрлэсэн огноо гэдэгт тухайн осолд орсон тээврийн хэрэгслийн үйлдвэрлэсэн огноог бичнэ. Тээврийн хэрэгслийн төрөл гэдэгт маягтад дурдсан сонголтуудаас зохихыг чагтална. Тээврийн хэрэгслийн гүйлт гэсэн хэсэгт тухайн тээврийн хэрэгслийн замыг км-ийн заалтаар бичнэ.

1.8. Даатгагч гэдэгт Жолоочийн даатгалын тухай хуулийн 3.1.3-т заасан “...даатгуулагчтай даатгалын гэрээ байгуулж, уг гэрээнд заасан нөхцөл,

хэмжээгээр хохирогчид нөхөн төлбөр олгох үүрэг хүлээсэн, жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй хуулийн этгээдийг” бичнэ.

1.9. Зам тээврийн осол гарсан шалтгаан гэдэгт чагтлах сонголттойгоор өгөгдсөн шалтгаануудаас тухайн осол гарахад шалтгаалсан гэж үзсэн шалтгааныг харалдаа байгаа нүдэнд чагталж бичнэ. “А” гэсэн хэсэгт тухайн осолд холбогдсон 1 талын жолооч “В” гэсэн хэсэгт нөгөө талын жолооч тэмдэглэгээ хийнэ.

1.10. Зам тээврийн осол гарсан хэлбэр гэдэгт осолд холбогдсон 2 жолооч “А” ба “В” талд чагтлах сонголттой заалтуудаас аль тохирохыг чагталж бичнэ.

1.11. Зам тээврийн осол гарсан замын нөхцөл байдал гэдэгт-тухайн зам тээврийн осол гарсан замын болон орчны нөхцөл байдлыг тодорхойлж бичнэ.

1.12. Замын хучилт гэдэгт замын зорчих хэсгийн гадаргууны хучилтыг тодорхойлох бөгөөд товчилсон асф-бет гэдгийг асфальт бетон, цем-бет гэдгийг цемент бетон гэж ойлгох бөгөөд эдгээрээс аль тохирохыг чагталж бичнэ.

1.13. Замын гадаргуугийн байдал гэдэгт зам тээврийн осол гарсан үеийн замын гадаргуу, хуурай, нойтон, мөстэй, цастай аль нь болохыг чагталж бичнэ. Мөн замын эвдрэл осолд нөлөөлсөн бол нэмж зурах нь зүйтэй.

1.14. Үзэгдэх орчин гэдэгт тухайн осол гарах үеийн үзэгдэх орчин ямар байсныг заалтуудаас сонгож чагталж бичнэ.

1.15. Цаг агаар гэдэгт тухайн осол гарах үед цаг агаар ямар байсныг үндэслэн бөглөнө.

1.16. Замын онцлог гэдэгт тухайн зам тээврийн осол гарсан зам нь огцом эргэлттэй бөгөөд тухайн зам нь осол гарах нөхцлийг бүрдүүлээгүй бол огцом эргэлт гэснийг сонгох шаардлагагүй. Бусад тохиолдлын аль тохирсоныг чагталж бичнэ.

1.17. Замын ангилал гэдэгт замын ангилалыг тодорхойлох бөгөөд аль тохирсоныг чагталж бичнэ.

1.18. Бусад гэсэн хэсэгт – тухайн зам тээврийн осол суурин болон суурингийн гадна гарсан эсэхийг тодорхойлох бөгөөд суурингийн замд гэдэг нь суурьшмал газрын замыг, суурингийн гаднах зам гэдэг нь суурьшмал газраас гадагш замыг ойлгоно. Тухайн осол хэзээ болсон гэдгээс шалтгаалж өдөр, шөнө гэсэн нүдэнд сонголтыг чагталж бичнэ.

1.19. Учирсан хохирол гэдэгт тухайн зам тээврийн ослын улмаас “А”, “В” жолооч тус бүр өөрсдийн автомашинд нийт хэдэн төгрөгийн хохирол учирсан мөнгөн дүнг бичнэ. Нөхөн төлүүлсэн гэдэгт тухайн учирсан хохирлын хэдийг нь төлүүлсэн мөнгөн дүнг бичиж өгнө.

1.20. Зам тээврийн ослын зураглал гэдэгт тухайн зам тээврийн осол болсон хэргийн газрын зураглалыг оруулж өгнө. Замын дүрслэл, “А” ба “В” тээврийн хэрэгслийн хөдөлгөөний чиглэл, “А” ба “В” тээврийн хэрэгслийн мөргөлдөх үеийн байрлал, “А” ба “В” тээврийн хэрэгслийн эцсийн байдал, замын тэмдэг, тэмдэглэгээ, гэрэл дохио зэргийг оруулна.

1.21. Анхны цохилт өгсөн газар гэдэгт “А” ба “В” талууд өөрсдийн тээврийн хэрэгслийн цохилт өгсөн газрыг зураг дээр сумаар тэмдэглэнэ. Тухайлбал, “А” талын тээврийн хэрэгслийн баруун урд талаас цохилт /мөргөлдсөн/ байвал тухайн тээврийн хэрэгслийн жолооч зураг дээрх дүрсний баруун урд хэсэгт сумаар зааж тэмдэглэгээ хийнэ.

1.22. Гэмтлийн нүдээр харагдах байдал гэсэн хэсэгт өөрийн тээврийн хэрэгслийн ямар эд ангид гадна талаасаа ямар эвдрэл учирсан байгааг бичнэ. Жишээ нь, Баруун талын гэрэл хагарч бутарсан, хаалга хонхойсон гэх мэтчилэн.

1.23. Өөрсдийн тээврийн хэрэгслийн талаар бичсэн жолооч тус бүр гарын үсэг зурж баталгаажуулна.

1.24. Зам тээврийн ослын товч утга гэдэгт тухайн зам тээврийн осол болсон талаар товч утгыг оруулж өгнө. Жишээ нь: 12-0... уб... дугаарын эксел маркийн цагаан өнгийн автомашин нь 55-0... уб... дугаарын саарал өнгийн ландкрузер маркийн автомашинтай мөргөлдсөн гэх мэт. Өөр нэмэлт мэдээлэлд оруулах шаардлагатай тохиолдолд товч утга дээр нэмж бичнэ.

1.25. Зам тээврийн осолд 2-оос дээш тооны тээврийн хэрэгсэл оролцсон бол тэдгээр тээврийн хэрэгслийн талаарх мэдээлэл гэдэгт тухайн гуравдагч /дөрөвдөгч гэх мэтчилэн/ тээврийн хэрэгслийн талаарх мэдээллийг 10, 11, 12 дугаар асуултад хариулан бичнэ.

1.26. Тээврийн хэрэгсэлд учирсанаас бусад хөрөнгөд учирсан хохирол гэдэгт гэмтсэн зүйлийн нэр төрөл, хэний хөрөнгө болох зэргийг баримтаар нотлогдвол товч тодорхой бичнэ.

1.27. Тээврийн хэрэгслийг хөдөлгөж явуулах боломжтой эсэх гэдэгт асуултын дагуу тийм, үгүй гэсэн сонголтыг чагталж бичнэ. “Үгүй” бол тээврийн хэрэгсэл хаана байгаа талаар тодорхой бичиж тэмдэглэнэ.

1.28. Тэмдэглэл гэдэгт тухайн зам тээврийн ослын талаар бусад мэдээллийг тэмдэглэн бичнэ.